# ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМ, МЭРГЭНИЙ ХӨНДИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/ АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-022597 /

/ АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5403316 /

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын шинжээч............................................................... / /

Төв аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын

газрын мэргэжилтэн................................................ /С.Эрдэнэцогт /

Биелэлтийг тайлагнасан:

“Хаш-Аранга” ХХК-ийн гүйцэтгэх захирал. .................................................. / Ч.Ганбат /

“Хаш-Аранга” ХХК-ийн байгаль

орчны мэргэжилтэн................................................ / Э.Намсрай /

2025 он

***ГАРЧИГ***

1. ОРШИЛ ..... 4
2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА ..... 4
2. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 4
3. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ ..... 5
3.1 Агаар ..... 5
3.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөц ..... 6
3.3 Хөрсөн бүрхэвч ..... 7
3.4 Ургамлан нөмрөг ..... 8
3.5 Амьтны аймаг ..... 8
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 9
5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 9
5.1 “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” ний хүрээнд 1000 ширхэг мод тарих ..... 9
6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 10
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 10
8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 10
9. ХОГ, ХАЯГДЛЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 12
9.1 Ахуйн хог хаягдал ..... 12
9.2 Аюултай хог хаягдал ..... 14
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ..... 14
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 16
12 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 18

## *ЗУРГЫН ЖАГСААЛТ*

*Зураг.1 Уурхайн кемп болон карьерт агаарын дээжний хэмжилт хийж буй байдал.... .6*
*Зураг.2 Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл,чихэвч ....8*
*Зураг.3 Эргэлтийн усан сан. ....9*
*Зураг.4 Шатхуун хадгалах агуулахын талбайг хайрган хучилт хийж байрлуулсан....9*
*Зураг.5 Уурхайн тээврийн замыг их бүрэн тэмдэгжүүлсэн ....9*
*Зураг.6 Явган хүний зам, талбайг зориулалтын дагуу хатуу хучилттай ....10*
*Зураг.7 Уурхайн замд хуваарийн дагуу усалгаа хийж ажилласан ....10*
*Зураг.8 Сургалтад хамрагдсан ажилчид, ан амьтан агнах хориотой тэмдэг....10*
*Зураг.9 Үерийн уснаас хамгаалах суваг шуудуу ....11*
*Зураг.10 Аянга зайлуулагч суурьлуулж ажиллаа ....11*
*Зураг.11 Газардуулга хийсэн ктп/ ....13*
*Зураг.12 Хөдөлмөр хамгааллын хувцас ....13*
*Зураг.13 Гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгсэл, Тусгай тоноглолтой галын машин ....14*
*Зураг.14 Хатуу хог хаягдал түр хадгалах, ангилан ялгах сав....14*
*Зураг.15 Ангилан ялгалтын хогын сав ....14*
*Зураг.16 Ангилан ялгалтын түр хогийн цэг ....15*
*Зураг.17 Төмрийн хог хягдал цуглуулах цэг байгуулав ....15*
*Зураг.18 Хаягдал тос хадгалах талбай. ....16*
*Зураг.19 Уурхайн кемп болон карьерт агаарын дээжний хэмжилт хийж буй байдал....16*
*Зураг.20 Уурхайн засварын талбай болон ШТС-аас хөрсний дээж авч буй байдал....17*
*Зураг.21 Уурхайн ахуйн бохир уснаас элс баяжуудах бохирийн уснаас дээж авч буй байдал ....17*
*Зураг.22 Хөдөлмөр хамгааллын хувцас ....18*
*Зураг.23 Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл ....18*
*Зураг.24 Сургалтад хамрагдсан ажилчид, сертификат. ....19*
*Зураг.25 Гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгсэл, Тусгай тоноглолтой галын машин ....19*

***ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ***

*Хавсралт.1 Улсын бүртгэлийн гэрчилгээ*

*Хавсралт.2 Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл*

*Хавсралт.3 Лавлагаа*

*Хавсралт.4 Усны гэрээ, дүгнэлт зөвшөөрөл*

*Хавсралт.5 Газар эзэмшүүлэх гэрээ*

*Хавсралт.6 Нөхөн сэргээлтийн 50% барьцаа байршуулсан баримт*

*Хавсралт.7 Сургалтад хамрагдсан сертификат*

*Хавсралт.8  2024 оны хог хаягдлын гэрээ*

*Хавсралт.9 Техникийн хаягдал тос, тосолгооны шингэний хаягдлыг хүлээлгэн өгөх гэрээ*

*Хавсралт.10 Газрын чанарын хянан магадалгаа хийх гэрээ*

## *1. ОРШИЛ*

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн A/619 тоот тушаалаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах батлах, тайлагнах журмын дагуу боловсруулаа. Төв аймгийн Сүмбэр сумын нутаг орших Мэргэний хөндийн алтны шороон ордыг 2025 онд олборлох явцад гүйцэтгэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ордын ашиглах ТЭЗҮ, БОННҮ, 2025 оны уулын ажлын төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулав.

Уг алтны шороон ордыг ашиглах төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг “Грийн солюшн консалтинг” ХХК 2024 онд хийж батлуулсан.

## 2. *ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА*

| | |
|---|---|
| **Төслийн нэр:** | “Мэргэний хөндий”-н алтны шороон ордыг ашиглах |
| **Төслийн ангилал:** | Монгол улсын “Байгаль орчны үнэлгээний тухай” хуулийн хавсралтын дагуу “Уул уурхайн төсөл” ангилалд хамаарна. |
| **Төслийн дугаар:** | MV-022597 |
| **Талбайн хэмжээ:** | 2315.14 га |

*Хүснэгт. 1 / Газар зүйн солбицол /*

| Цэг | Уртраг | Өргөрөг | Нийт талбайн хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | 104 29'00" | 48 17'43" | 2315.14 га |
| 2 | 104 29'05.74" | 48 17'43" | |
| 3 | 104 29'05.74" | 48 17'42.4" | |
| 4 | 104 29'11.34" | 48 17'42.43" | |
| 5 | 104 29'11.34" | 48 17'41.91" | |
| 6 | 104 29'15.71" | 48 17'41.93" | |
| 7 | 104 29'15.72" | 48 17'40.96" | |

Төв аймгийн Сүмбэр сумын нутагт орших Загдал нэртэй MV-022597 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн Мэргэний хөндийн алтны шороон ордыг ашиглах төслийг АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2023 оны 09-р сарын 04-ны өдрийн 292 тоот шийдвэрээр “ХАШ-АРАНГА” ХХК-д олгосон байна.

MV-022597 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь засаг захиргааны хуваариар Монгол улсын хойд хэсэг, Төв аймгийн Сүмбэр сумын нутагт харьяалагдах бөгөөд сумын төвөөс хойш 6.5 км-т, Бага бор уулаас зүүн урагш 3 км-т оршино.

## *2. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА*

**Уулын ажлын төлөвлөгөө**

Мэргэний хөндийн алтны шороон ордын MV-022597 талбайн хэмжээнд 2025 онд зөвхөн угаан баяжуулах ажил хийж гүйцэтгэсэн.

Үүнд:

- Элс угаалт 16.37 мян.м3

# 3. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

## 3.1 Агаар

Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх

### 3.1.1 Тоосжилт болон агаар бохирдуулдаг хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих. Стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авах



| № | Байршил | Сар өдөр | Хүхэрлэг хий /$SO_2$/ мг/м$^3$ | Азотын хий /$NO_2$/ мг/м$^3$ | Тоосны агууламж PM10 мг/м$^3$ | Дуу чимээ /ДБА/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Уурхай хотхон | IX/21 | 0.029 | 0.038 | 1 | 40 |
| 2. | Карьер | IX/21 | 0.026 | 0.042 | 3 | 42 |
| | **MNS 4585:2016 стандарт** | - | **0.450** | **0.200** | **50** | **60.0** |

*Зураг.1 Уурхайн кемп болон карьерт агаарын дээжний хэмжилт хийж буй байдал*

### 3.1.2 Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тээвэрлэсэн автомашиныг хучиж, хөрс, элсний тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх

2025 онд зөвхөн элс угаан баяжуулах ажил хийгдсэн учир, тээвэр хийгдээгүй болно.

### 3.1.3 Уурхайн олборлолт дуу шуугианы бохирдолтой нөхцөлд ажилладаг ажилчдад толгой хамгаалах хэрэгсэл-сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл (бөглөө, чихэвч)-ийг зүүлгэж хэвшүүлэх тухай аулгүй ажиллагааны дүрэм журамд нь тусгаж, хэрэгжүүлэх





*Зураг.2  Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл,чихэвч*

### 3.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөц

*Ус шавхан зайлуулалтын улмаас газрын доорх усанд хомстол үүсэх*

#### 3.2.1 Шүүрлийн усыг хуримтлуулан технологийн усны хэрэглээнд ашиглах, технологийн усан хангамжид хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглах.

Уурхайн эргэлтийн усан сан байгуулсан бөгөөд 70:30 гэсэн харьцаагаар тунаах нууранд цэвэршүүлэн эргүүлэн ашигладаг.





*Зураг.3 Эргэлтийн усан сан*

#### 3.2.2 Ус ашиглах дүгнэлт гаргуулж төлбөрийг төлөх

*Хавсралт.4 2025 оны ус ашиглах гэрээ, дүгнэлт төлбөр төлсөн баримт*

#### 3.2.3 Ундны усны эх үүсвэрт тогтмол хими-бактериологийн шинжилгээ хийлгэж шаардлага хангаж байгаа эсэхийг тогтмол хянах

*Хавсралт.4 Бактериологийн шинжилгээний хариу*

#### 3.2.4 Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл,гэрээ байгуулан төлбөр төлж барагдуулах

2025 оны 9 дугаар сарын 19-ний өдрын Дугаар E-250-00152 бүхий ус ашиглуулах дүгнэлтээр Хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулахаар заасан.

### 3.3 Хөрсөн бүрхэвч

**3.3.1 Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийгажлын талбайд гаргахгүй байх**




*Зураг.4 Шатхуун хадгалах агуулахын талбайг хайрган хучилт хийж байрлуулсан*

**3.3.2 Уурхайн технологийн дотоодын болон гадаад тээвэрлэлт, үйлчилгээний зориулалтын тээврийн хэрэгслийн зорчих сайжруулсан зам, талбайг иж бүрэн тэмдэгжүүлэн, тээврийн хэрэгсэл, уулын машин механизмын хөдөлгөөнийг заасан маршрутаар хязгаарлах**



*Зураг.5 Уурхайн тээврийн замыг их бүрэн тэмдэгжүүлсэн.*

**3.3.3 Уурхайн ажилчид, суурин дахь захиргаа үйлчилгээний ажиллагсдын зорчих явган хүний зам, талбайг зориулалтын дагуу хатуу хучилттайгаар байгуулан, тэмдэгжүүлэх**



*Зураг.6 Явган хүний зам, талбайг зориулалтын дагуу хатуу хучилттай болгосон.*

**3.4 Ургамлан нөмрөг**

Уурхайн болон ажилчдын хотхоны үйл ажиллагааны улмаас ургамлан бүрхэвч доройтох

**3.4.1. Хэт хуурайшилттай, салхи ихтэй нөхцөлд газрыг чийглэж услаж байх**



*Зураг.7  Уурхайн замд хуваарийн дагуу усалгаа хийж ажилласан.*

**3.4.2 Хүн болон машин техникийг хөдөлгөөнийг тогтсон маршрутын дагуу явуулах**

2025 онд зөвхөн элс угаан баяжуулах ажил хийгдсэн учир, тээвэр хийгдээгүй болно.

***3.5 Амьтны аймаг***

Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр зэрлэг амьтад дайжих, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх

**3.5.1 Төслийн ажиллагсад болон гэрээлэгчдийг галт зэвсэг хэрэглэхгүй байх болон ан агнуурын талаархи бодлогыг мөрдүүлэхэд анхаарах**

Ажиллагсдад ан амьтан хамгаалах хууль дүрэм журмыг мөрдүүлэх, байгальд элдэв сөрөг үйлдэл гаргуулахгүй байхад анхаарч сурталчилгааны ажил тогтмол зохиож байх

Хурдны хязгаарыг байнга барих, зам тээврийн үед амьтан алахгүй байх, амьтны нүүдлийн төлөв болон үржлийн хэв маягт саад учруулахгүй байх талаар сургалт явуулсан бөгөөд ажилчдад болон тээвэрлэлтэд оролцох ажилчдад хамгааллын статус бүхий ховор амьтдын ач холбогдол, ан агнуур, худалдааг хориглох тэмдэг байршуулсан.



*Зураг.8 Сургалтад хамрагдсан ажилчид, ан амьтан агнах хориотой тэмдэг*

## 4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Мэргэний хөндийн алтны шороон ордын MV-022597 талбайн хэмжээнд 2025 онд зөвхөн угаан баяжуулах ажил хийж гүйцэтгэсэн.

Үүнд:

- Элс угаалт 16.37 мян.м3.

## 5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Төв аймгийн Сүмбэр сумын төвд 1000 ширхэг навчит модны суулгацаар ойжуулалт хийхээр 2025 оны 11 сард ойн мэргэжлийн байгууллага “Жигд ой” ххк-тай гэрээлэн хийж гүйцэтгэж байна.

### *5.1 “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” ний хүрээнд 1000 ширхэг мод тарих*

Төв аймгийн Сүмбэр сумын төвд 1000 ширхэг навчит модны суулгацаар ойжуулалт хийхэр 2025 оны 11 сараас 2026 оны 5 сар хүртэл ойн мэргэжлийн байгууллага “Жигд ой” ххк-тай гэрээлэн хийж гүйцэтгэж байна.

## 6. *НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ*

Төслийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний ажил хийгдэхгүй болно.

## 7. *ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ*

*Ашиглалтын талбайд* олборлолтын үйл ажиллагаанд түүх соёлын өвүүд илэрээгүй болно.

## 8. *ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ*

Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах

### 8.1 Хур бороо, үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу татах



*Зураг.9 Үерийн уснаас хамгаалах суваг шуудуу*

### 8.1.2 Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах



*Зураг.10 Аянга зайлуулагч суурьлуулж ажиллаа.*

**8.1.3 ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх**




*Зураг.11 Газардуулга хийсэн байдал*

**8.2 Хувь хүний хамгаалах хэрэгслүүдийг тухайн ажлын байрны онцлогт тохируулах тогтмол хэрэглэж хэвшүүлэх, хангах**




*Зураг.12 Хөдөлмөр хамгаалллын хувцас*

**8.3 Гал унтраах анхан шатны болон суурин тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах засвар, үйлчилгээг цаг тухайд нь хийж тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.**




*Зураг.13 Гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгсэл, Тусгай тоноглолтой галын машин*

## *9. ХОГ, ХАЯГДЛЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ*

### *9.1 Ахуйн хог хаягдал*

**9.1.1 Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх**

Ангилан ялгалтын цэгийг тохижуулж, дахин боловсруулах, ашиглах боломжтой хог хаягдлыг цуглуулан ажиллав.



*Зураг.14 Хатуу хог хаягдал түр хадгалах, ангилан ялгах сав*

### 9.1.2 Ангилан хаях хогын сав байршуулах




*Зураг.15 Ангилан ялгалтын хогын сав*

### 9.1.3 Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, тэсрэх материалын агуулах, ШТС зэрэг газарт байрлуулах

Хог хаягдлаа ангилан ялгадаг бөгөөд эх үүсвэр болгон дээр ангилан ялгалтын хогийн сав байршуулсан.




*Зураг.16 Ангилан ялгалтын түр хогийн цэг*

### 9.1.4 Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх

Төмрийн хог хаягдал цуглуулах цэг байгуулсан бөгөөд дахин ашиглах боломжтой тул дахиварт өгөөгүй болно.



*Зураг.17 Төмрийн хог хягдал цуглуулах цэг байгуулав*

### *9.2 Аюултай хог хаягдал*

**9.2.1 Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх**

Хуучин тосны цэг гарган ажилласан тос тосолгооны материалаа хадгалсан. Мөн аккумлятор дахин ашигласанаар хаягдал гараагүй болно.

*/ Хавсралт.9 Аюултай хог хягдал нийлүүлэх гэрээ /*




*Зураг.18 Хаягдал тос хадгалах талбай*

## *10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ*

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Хаш-Аранга” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай..

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Хаш-Аранга” ХХК хариуцах болно.

### 10.1 Агаарын чанар

Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 шаардлагад тоосонцорын агууламж /PM 5.0, PM 10/, хүхэрлэг хий, азотын давхар исэл зэрэг агаарын чанрын үзүүлэлтүүдийг бидний хэмжилт хийсэн уурхайн ухаш, тээвэрлэлтийн зам зэрэгт хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна. Бидний шинжилгээний үр дүнгээс харахад агаарын чанарын стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна



*Зураг.19 Уурхайн кемп болон карьерт агаарын дээжний хэмжилт хийж буй байдал*

*Хүснэгт.4 Агаарт буй тоосонцорыг хэмжсэн үзүүлэлтүүд*

| № | Байршил | Сар өдөр | Хүхэрлэг хий /$SO_2$/ мг/$м^3$ | Азотын хий /$NO_2$/ мг/$м^3$ | Тоосны агууламж PM10 мг/$м^3$ | Дуу чимээ /ДБА/ | Чийгшил |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Уурхай хотхон | IX/21 | 0.029 | 0.038 | 1 | 40 | |
| 2. | Карьер | IX/21 | 0.026 | 0.042 | 3 | 42 | max42.4% min17.4% |
| 3. | Тээвэрлэлтийн зам | IX/21 | 0.058 | 0.077 | 5 | 42 | |
| | **MNS 4585:2016 стандарт** | **-** | **0.450** | **0.200** | **50** | **60.0** | 40-60% |

## 10.2 Хөрсөн бүрхэвч



*Зураг.20 Уурхайн засварын талбай болон ШТС-аас хөрсний дээж авч буй байдал*

### 10.3 Усан орчин

Уурхайн унд ахуйн ус, цэврийн нуур, бохирын нуур, кемпийн ахуйн бохирын септик танкнаас гарсан шүүрүүлэх талбай зэргээс дээж авж итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн болно.



*Зураг .21 Уурхайн ахуйн бохир уснаас элс баяжуудах бохирийн уснаас дээж авч буй байдал*

## *11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ*

### 11.1 Ажиллагсдыг тусгай хувцас хэрэгслээр бүрэн хангах

Жил бүрийн ХАБЭА төсөв гарган хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлээр хүрэн хангаж ажилласан.




*Зураг.22 Хөдөлмөр хамгааллын хувцас*

## 11.2 Нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах

Нийт ажилчдыг нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан (Каск, нүдний шил, ажлын хувцас, ажлын гутал, чихний бөглөө, ажлын бээлий) гэх мэт**.**



*Зураг.23 Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл*

## 11.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, гал түймэр, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах

“Хаан булаг интернэйшл” ХХК нь 2025.05 сард “Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх уул уурхайн аврах 09 дүгээр анги”-с Уурхайн,уулын үйлдвэрт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний мэдлэг, дадлага олгох сургалтад авсан. / *Хавсралт.7 Сургалтад хамрагдсан сертификат/*



БАТЛАМЖ

Хаанбулаг интернэйшнл ХХК-Д

Уурхай, уулын үйлдвэрт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний мэдлэг, дадлага олгох сургалтад хамрагдсан тул “Батламж” олгов.

УУЛ УУРХАЙН АВРАХ 09 ДҮГЭЭР АНГИ

2025 он

*Зураг.24 Сургалтад хамрагдсан ажилчид, сертификат*

**11.4 Байгаль хамгаалал, болзошгүй түймрээс урьдчилан сэргийлэх талаар ухуулга, сурталчилгааны самбар хийж байрлуулан, тухай бүрд нь шинэчилж бай -Гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулах**




*Зураг.25 Гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгсэл, Тусгай тоноглолтой галын машин*

## 12 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 12.1 Сүмбэр сумын 2-р багийн иргэд

Уурхайн нөлөөллийн бүсэд орших малчдад уурхайн үйл ажиллагаа ажлын явцыг танилцуулсан.

### 12.2 Төв аймгийн Байгаль орчны газар

Цахим систем болох www.eic.mn 11 сарын 1-ний дотор бичвэр мэдээллийг орууллаа

### 12.3 Төрийн захиргааны төв байгууллага

Цахим систем болох www.eic.mn 11 сарын 1-ний дотор бичвэр мэдээллийг орууллаа.

# 13. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЗАРДЛЫН НЭГТГЭЛ

*Хүснэгт.5 Байгаль орчны хамгаалах зардлын нэгдэл*

| Д/д | **Байгаль орчны менежментийн төлөвлөгөө** | Үнийн дүн / мян.төг | **Үнийн дүн / мян.төг /** |
|---|---|---|---|
| **1** | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | **4 500.0** | **4 500.0** |
| **2** | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | **-** | **-** |
| **3** | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | **10 000.0** | **10 000.0** |
| **4** | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | **-** | **-** |
| **5** | Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө | **-** | **-** |
| **6** | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | **3 000.0** | **3 000.0** |
| **7** | Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал | **4 000.0** | **4 000.0** |
| **8** | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) | **1 500.0** | **1 500.0** |
| **9** | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | **1 500.0** | **1 500.0** |
| **10** | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | **-** | **-** |
| **Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт** | | **23500.0** | **23500.0** |

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

№ 000070092

2010.08.31
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011250023
/ Улсын бүртгэлийн дугаар /

5403316
/ Регистрийн дугаар /

Хаш-Аранга Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Тогтоол | 01 | 2010.08.31 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| 7110 | Геофизикийн судалгаа хийх |
|---|---|
| / код / | / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

| Хугацаагүй | 4 | 1,000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Баянзүрх, 5-р хороо, энхтайваны өргөн чөлөө, 64 АМО байр 3-р давхар . Утас1: 99111485, Утас2: 99111370, Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2013 он 12 сар 16 өдөр

## Харилцах дансны бүртгэл

| Харилцагч банкны нэр | Дансны төрөл | Дансны дугаар | Бүртгэсэн ажилтан тэмдэг |
|---|---|---|---|
| ХААН банк | Төгрөгийн | 5009364350 | Ч.Батцэцэг |

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Сэнгээ овогтой Мөнхбаатар-г Захирал-р томилсныг бүртгэв. | 2013.12.16 | Д.Аюурзана |
| 2 | Дахин гэрчилгээ олгов | 2013.12.16 | Д.Аюурзана |
| 2 | Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 4 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2016.08.26 | М.Монголжин |
| 3 | Чулуунбат овогтой Ганбат -г Захирал-р томилсныг бүртгэв. | 2016.08.26 | М.Монголжин |
| 4 | Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 4 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2016.08.30 | С.Мөнхсанчир |
| 5 | Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 4 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2016.12.06 | Ж.Аюуш |
| 6 | 0990 Ашигт малтмалын хайгуул эрхлэх /2016.04.04-2019.04.04/ эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2018.05.28 | О.Шижиртуяа |
| 7 | Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв. | 2020.10.21 | Б.Батзориг |

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР УЛСЫН БҮРТГЭГЧ 538

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

## АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

# ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар ***MV-022597***

Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн ***Төв*** аймаг /хот/-ийн ***Сүмбэр*** сум /дүүрэг/-ын ***Загдал*** нэртэй газарт орших ***2315.14*** гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч улсын бүртгэлийн ***9011250023*** тоот гэрчилгээтэй ***"Хаш-Аранга" ХХК***-д энэхүү тусгай зөвшөөрлийг ***2053.09.04*** дуустал хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.БАТМАГНАЙ

2023 оны 9 дүгээр сарын 4 ний өдөр

Улаанбаатар хот

0000690

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

**MV-022597**

**Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.**

| Дэс дугаар | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Огноо, гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|
| 001-NM | • Бүртгэв: Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 2023.09.04, дуусах хугацаа 2053.09.04<br>• Тусгай зөвшөөрлийн 1 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв<br>• Кадастрын хэлтсийн даргын 2023.09.04-ний 292 тоот шийдвэр | 5 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043<br>2023.09.04 |
| | | |
| | | |
| | | |
| | | |
| | | |
| | | |

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

**MV-022597**

**Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.**

| Дэс дугаар | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/ | Хасагдах талбайн хэмжээ /га/ | Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | # | Уртраг | Өргөрөг |
| 001-NM | • Ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх олгосон 2023.09.04 | 2315.14 Га | 0 Га | 1 | 105° 53' 1.15'' | 48° 51' 41.86'' |
| | | | | 2 | 105° 53' 1.15'' | 48° 50' 1.87'' |
| | | | | 3 | 105° 54' 46.8'' | 48° 50' 1.87'' |
| | | | | 4 | 105° 54' 46.8'' | 48° 50' 1.39'' |
| | | | | 5 | 105° 51' 47.64'' | 48° 47' 50.99'' |
| | | | | 6 | 105° 50' 31.16'' | 48° 47' 50.99'' |
| | | | | 7 | 105° 50' 31.16'' | 48° 51' 41.86'' |
| | | | | Ш.Мандахжаргал 2023.09.04 | | |

3 ... КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТ0/043

# ЛАВЛАГАА
## Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-022597




### ТАНИХ ТЭМДЭГ

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл
- Ашиглалтын
- Хайгуулын

Засаг захиргааны хил
- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Аймгийн төв
- Сумын төв

Тусгай хамгаалалттай газар нутаг
- Дархан цаазат газар
- Байгалийн цогцолборт газар
- Байгалийн нөөц газар
- Дурсгалт газар

Хамгаалалтын бүсүүд
- Гол мөрний урсац бүрэлдэх эх
- Ойн сан бүхий газар

Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс
- Онцгой хамгаалалтын бүс
- Энгийн хамгаалалтын бүс

Ус хангамжийн эх үүсвэр
- Эрүүл ахуйн хориглолтын бүс
- Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс
- Тэжээгдлийн муж

Орон нутгийн усны хамгаалалтын бүс
- Орон нутгийн усны хамгаалалтын бүс

Масштаб 1:63555.0




Аймаг, сум, сав газрын нэр: Төв аймаг Сүмбэр сум, Хараа голын сав газар

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР

Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтэс

Засгийн газрын 2012 оны 194, 2015 оны 289-р тогтоолоор батлагдсан гол, мөрний урсац бүрэлдэх эхтэй давхцалгүй, ойн сантай давхцалгүй, усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалгүй, улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна. Орон нутгийн усны энгийн болон онцгой хамгаалалтын бүстэй давхцалгүй байна.

Боловсруулсан: ахлах мэргэжилтэн Э.Эрдэнэхүү /............/

Огноо: 2024-06-05

## ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМАНД ОЙЖУУЛАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2025 оны 11 сарын 10 өдөр Дугаар: 03 Улаанбаатар хот

Нэг талаас 5403316 тоот регистрийн дугаартай “Хаш-Аранга” ХХК, түүнийг төлөөлөн гүйцэтгэх Захирал Чулуунбат овогтой Ганбат (цаашид захиалагч гэх), нөгөө талаас 6762344 тоот регистрийн дугаартай “Жигд Ой” ХХК, түүнийг төлөөлөн захирал Төмөрбаатар овогтой Энэрэл (цаашид гүйцэтгэгч гэх), нар (хамтад нь талууд гэх) дараах нөхцөлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

### 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Төв аймгийн Сүмбэр сумын төвд 1000 ширхэг навчит модны суулгацаар ойжуулалтын ажил хийх, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Энэхүү гэрээг байгуулахад талууд гэрээний бүх зүйл заалттай танилцаж, хүлээн зөвшөөрч, хүсэл зорилгоо бүрэн илэрхийлсэн болно. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

### 2. ЗАХИАЛАГЧЫН ЭРХ, ҮҮРЭГ

Захиалагчын эрх

2.1. Захиалагч тал нь гүйцэтгэгч талаас тариалалтын шаардлага хангасан тарьц суулгацаар ойжуулалтын ажил гүйцэтгэхийг шаардах,

2.2. Шаардлага хангахгүй гүйцэтгэтгэсэн тохиолдолд хүлээн авахаас татгалзаж залруулах талаар хүсэлт гаргах,

2.3. Мод тарих болон арчилгаа, хамгааллын талаар мэдээлэл, зөвлөгөө авах,

Захиалагчын үүрэг

2.4. Гүйцэтгэгч “Жигд Ой” ХХК-ны Голомт банкин дахь 1245123823 тоот дансанд ойжуулалтын ажлын нийт дүн болох 10,000,000 (арван сая) төгрөгийн шилжүүлнэ. Ингэхдээ ажил эхлэхээс өмнөх урьдчилгаа 70 хувь болох 7,000,000 (долоон сая) төгрөгийг гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулсны дараа нэхэмжлэхийн дагуу ажлын 5 хоногт, ойжуулалт хийгдэж дуусан ажлын гүйцэтгэлийн тайлан хүлээлгэн өгсний дараа үлдэгдэл төлбөр 30 хувь болох 3,000,000 (гурван сая) төгрөгийг нэхэмжлэхийн дагуу ажлын 5 хоногт багтаан шилжүүлэх

2.5. Тарилт хийх талбайг гүйцэтгэгч талд зааж өгч мэдээллээр хангах

2.6. Гүйцэтгэгч талтай хамтран 2026 оны хаврын тарилтын хугацаанд багтаан гүйцэтгэсэн ойжуулалтын ажлыг комисс гарган хүлээн авах

### 3. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Гүйцэтгэгчийн эрх

3.1 Гэрээт ажлыг хугацаанд нь чанартай сайн гүйцэтгэсэн тухай ажлын тайланг үндэслэн санхүүжилтийг бүрэн нэхэмжлэх

3.2 Ойжуулалтын ажлыг хүлээлгэн өгсөнөөс хойш үүссэн аливаа асуудлыг хариуцахгүй байх

Ан.Б

Гүйцэтгэгчийн үүрэг

3.3. Стандартын шаардлага хангасан үндэс сайтай, амьдралтын хувь өндөртэй Улиасны 500ш, Хайлиасны 300ш, Агчны 200ш нийт 1000ш суулгацыг технологийн дагуу бэлтгэн, ачиж тээвэрлэх.

3.4. Захиалагч талаас заасан талбайд тарилт хийж нөхөн тарилт, усалгаа арчилгааг гэрээний хугацаанд хэрэгжүүлэн хүлээлгэн өгөх

3.5. Цаашид арчлан, хамгаалах заавар, зөвлөмжөөр захиалагч талыг хангах

## 4. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

4.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг буруутай тал бүрэн нөхөн төлнө.

## 5. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

5.1. Гэрээ нь талууд харилцан гарын үсэг зурж батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
5.2. Гэрээг 2025 оны 11 сарын 10-ны өдрөөс 2026 оны 05 сарын 30-ныг дуустал хугацаатай байгуулав.
5.3. Гэрээний хэрэгжилтийн явцтай уялдуулан талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний хүчинтэй хугацааг сунгаж болно.

## 6. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

6.1. Талуудын харилцан найрсаг хамтын ажиллагааг эрхэм болгож ажиллана.
6.2. Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлнэ.
6.3. Талууд гэрээг цуцлах нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа ажлын 3 хоногоос доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа мэдэгдэх бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй нэг хэсэг болж гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр байна. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр гаргасан хамтарсан мэдэгдлийг үндэслэн гэрээг цуцалж, дуусгавар болгож болно.

## 7. БУСАД

7.1. Гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талууд тус бүрд 1 хувь хадгалагдана.
7.2. Гэрээг нэг талын санаачилгаар цуцлахгүй.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| ЗАХИАЛАГЧ: | ГҮЙЦЭТГЭГЧ: |
|---|---|
| "ХАШ-АРАНГА" ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ | "ЖИГД ОЙ" ХХК-НЫ ЗАХИРАЛ |
| Ч.ГАНБАТ | Т.ЭНЭРЭЛ |
| УТАС: | УТАС: 99991645 |

УЛААНБААТАР ХОТ ХАШ-АРАНГА ХХК

УЛААНБААТАР ХОТ ЖИГД ОЙ ХХК ШТМ1581 9011091220 6762344

# УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 09 -р
сарын 19 -ны өдөр

Дугаар E-2509-000152

Улаанбаатар хот Утас:
265528, 265578

## 1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

| | |
|---|---|
| Оноосон нэр: | Хаш-Аранга ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | |
| Регистрийн дугаар: | **5403316** |
| Захирал: | **Ганбат** |
| Холбоо барих дугаар: | **99111485** |
| Факс : | |
| И-мэйл хаяг : | |

## 2.Төслийн нэр байршил

| | |
|---|---|
| Төслийн нэр: | **Мэргэний хөндий алтны шороон орд** |
| Байршил: | **Төв, Сүмбэр, 2-р баг, Жавхлант** |
| Харьяалагдах сав газар: | **Хараа голын сав газар** |
| Хамаарах салбар: | **Уул уурхай** |
| Төслийн дэлгэрэнгүй: | **2024 онд хөрөнгө оруулалт, санхүүжилт хойшлогдсоны улмаас төлөвлөгөөний тасалдал үүсэж биелэлт хангагдаагүй, мөн улирлын хүйтрэл эхэлсэнтэй холбоотойгоор B-12 нөөцийн блокоос олборлосон 16.37 мян.м3 элсийг баяжуулалтад хамруулалгүй нөөцлөн хадгалсан болно.<br>Манай компанийн нь хөрөнгө оруулалт, санхүүжилт бүрэн шийдэгдээгүйн улмаас 2025 онд B-12 нөөцийн блокоос олборлосон 16.37 мян.м3 элсийг баяжуулалтад хамруулахаар төлөвлөж байна.** |

## 3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

**Хаш-Аранга**

## 4. Ажиллах горим, хүчин чадал

| Үргэлжлэх хугацаа | Ажиллах горим | Жилд ажиллах хоног | Хоногт ажиллах ажилчидын тоо | Хоногт ажиллах цаг |
|---|---|---|---|---|
| 3 | 2 ээлжээр | 30 | 18 | 12 |

## 5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
| --- | --- | --- | --- |
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 138.0 | хоногт 1 хүн | Уулын ажлын төлөвлөгөө маягт-3 аас ажиллах хоногийг тооцоолж, маягт-12 аас ажиллах хүчний тоог авсан. |
| Ашигт малтмал олборлон баяжуулахад ашиглах усны хэмжээ | 142200.0 | тонн | Эргэлтийн усны хэмжээг 85%(483480 м3) нөхөн сэлбэлтийн 15%(85320 м3) ТЭЗҮ (75х), БОННҮТ(43х) авсан. / шүүрлийн уснаас нөхөн сэлбэлтийн усыг авсан болно./ |
| Зам, талбайн тоосжилт дарах усалгаа. | 43000.0 | м2 | БОННҮТ-ийн (44х) зам ,талбайн тоосжилт дарах усалгааны хэмжээ, хугацааг авсан. |
| "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглах усны хэмжээ | 1000.0 | ш | Уулын ажлын төлөвлөгөөний маягт 10-т 1 га газарт 1000 ш мод тарихаар төлөвлөсөн байна /99060619 Эрдэнэбаяр/ |
| Дүйцүүлэн хамгаалахад зарцуулах усны хэмжээ | 50000.0 | м2 | 2025 оны Уулын ажлын төлөвлөгөө Маягт 10-т Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгаас санал болгосон талбайд ургамжуулах, мод тарих ажлыг хийж гүйцэтгэнэ. |
| Шүүрлийн ус | 735.3 | м3 | УАБНД, БОННҮТ-ын 44-р хуудас, ТЭЗҮ 77-р хуудас зэргийг үндэслэв. |

## 6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

| Эх үүсвэр | Зориулалт | Усны нөөц (л) | Усны нөөц (м3) | Тайлбар |
| --- | --- | --- | --- | --- |
| Гүний худаг | Ахуйн хэрэгцээнд | 4.0 | 345.6 | |
| Шүүрлийн ус | Усны хэрэглээ | 8.51 | 735.264 | Ил уурхайн малталтад хоногт хамгийн ихдээ 735.2 м3/хон буюу 8.51л/сек хэмжээтэй ус шүүрэх (ТЭЗҮ 77х) (БОННҮТ 45х) УАБНД |

## 7.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ : **Грийн солюшн консалтинг ХХК**

Холбоо барих : **95869576**

Нэмэлт мэдээлэл:

## 8. Усны барилга байгууламжууд

| Барилга байгууламж | Хүчин чадал (м3) | Хэмжээ хийц |
| --- | --- | --- |
| Усан сан | 10672.0 | 60м өргөн, 62м урт, 4м гүн |

## 9. Дамжуулах байгууламж

| Хаанаас (эхлэх цэг) | Хаана хүртэл (төгсгөлийн цэг) | Шугамын голч, мм | Дамжуулах шугамын урт, м |
| --- | --- | --- | --- |

## 10. Онцгой нөхцөл

- Усны тухай хуулийн 30.1.2-т заасны дагуу усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах үүрэгтэй тул хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд ус ашиглуулах дүгнэлт гаргахгүй байхыг анхаарах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах;
- Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглоно;
- Голын хамгаалалтын бүсэд хөрс хуулалт, олборлолт явуулахыг хориглоно;
- Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа голыг хамгаалах арга хэмжээ авах, хөв цөөрөм байгуулах, татмын ойжуулалт хийх г.м;
- Хаягдлын сангийн зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, Усны газраар дүгнэлт гаргуулах;
- Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газарт ирүүлэх;
- Газрын доорх усны түвшин өөрчлөлтийн хэмжилтийг тогтмол хийж, мэдээллийн санд оруулж байх;

## 11. Усны зарцуулалт

| Ажлын нэр | Тоо Хэмжээ | Хэмжих нэгж | Усны хэрэглээ, м3 (Норм) | Гүйцэтгэх давтамж | Хэмжих нэгж | Нийт ашиглах усны хэмжээ, м3 | Хөнгөлөх усны хэмжээ м3 | Төлбөр тооцох усны хэмжээ м3 |
| --- | --- | --- | --- | --- | --- | --- | --- | --- |
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 138 | хоногт 1 хүн | 0.15 | 300.0 | Хоног | 6,210.00 | 0.00 | 6,210.00 |
| Ашигт малтмал олборлон баяжуулахад ашиглах усны хэмжээ | 142200 | тонн | 4.0 | 1.0 | Удаа | 568,800.00 | 568,800.00 | 0.00 |
| Зам, талбайн тоосжилт дарах усалгаа. | 43000 | м2 | 0.002 | 21.0 | Удаа | 1,806.00 | 1,806.00 | 0.00 |
| "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглах усны хэмжээ | 1000 | ш | 0.035 | 21.0 | Удаа | 735.00 | 735.00 | 0.00 |
| Дүйцүүлэн хамгаалахад зарцуулах усны хэмжээ | 50000 | м2 | 0.004 | 12.0 | Удаа | 2,400.00 | 2,400.00 | 0.00 |
| Шүүрлийн ус | 735 | м3 | 1.0 | 300.0 | Хоног | 220,590.00 | 0.00 | 220,590.00 |
| **Нийт** | | | | | | **800,541.00** | **573,741.00** | **226,800.00** |

## 12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

| Ажлын нэр | Төлбөр тооцох усны хэмжээ, м3 | Усны ангилал | Хөнгөлөх хувь хэмжээ, % | 1 м3 усны үнэ | Усны нөөц ашигласны төлбөр, ₮ | Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮ | Төлбөл зохих дүн, ₮ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 6210.00 | Газрын доорх ус | 0.0 | 82.92 | 514,933.20 | 0.0 | 514,933.20 |
| Ашигт малтмал олборлон баяжуулахад ашиглах усны хэмжээ | 0.00 | Газрын доорх ус | 0.0 | 1354.36 | 0.00 | 0.0 | 0.00 |
| Зам, талбайн тоосжилт дарах усалгаа. | 0.00 | Газрын доорх ус | 0.0 | 165.84 | 0.00 | 0.0 | 0.00 |
| "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглах усны хэмжээ | 0.00 | Газрын доорх ус | 0.0 | 69.10 | 0.00 | 0.0 | 0.00 |
| Дүйцүүлэн хамгаалахад зарцуулах усны хэмжээ | 0.00 | Газрын доорх ус | 0.0 | 69.10 | 0.00 | 0.0 | 0.00 |
| Шүүрлийн ус | 220590.00 | Газрын доорх ус | 0.0 | 580.44 | 128,039,259.60 | 0.0 | 128,039,259.60 |
| **Нийт** | **226,800.00** | | | | **128,554,192.80** | | **128,554,192.80** |

### 13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

- Ахуйн хэрэгцээнээс гарч буй бохир усыг стандартын шаардлагад нийцтэл цэвэршүүлэн эргүүлэн ашиглах.

-- Газрын доорх усны ордын усны түвшний хэлбэлзэл, төлөв байдлыг тогтмол хянах;

### 14. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Хараа -Ерөө голын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах;
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахгүй байх;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус татах шугам хоолой бүрд баталгаажуулсан онлайн тоолуур суурилуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;
- Үйл ажиллагаа зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж ажиллах;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт-шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах.

**Ирээдүй хойч үедээ усны нөөцөө үлдээхийн төлөө усаа хамгаалья, хуримтлуулья, хамтран ажиллая!**

## Боловсруулсан:

| | |
|---|---|
| УС АШИГЛАЛТЫН ХЭЛТЭС | **Г.ГАНСЭЛЭМ** |
| Боловсруулсан огноо: | **2025.09.18** |

ЦАХИМ
БАТАЛГААЖЛАА
ГАРЫН ҮСЭГ

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | **Усны газар** |
| Газар хэлтэс: | **Удирдлага** |
| Албан тушаал: | **Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч** |
| Овог нэр: | **Зэнээмядар Батбаяр** |
| Зурсан огноо: | **2025.09.19 16:28:38** |

Батлав:
Хараа-Ерөө голын сав газрын захиргаа-ны дарга
......................О. Ариунбаатар

Батлав:
"Хаш-Аранга" ХХК- ний Гүйцэтгэх захирал
......................Ч.Ганбат

# УС АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2025 оны 09 сарын 29 –ны өдөр Дугаар № 31 Дархан-Уул аймаг

## Нэг. Ерөнхий зүйл

Монгол улсын "Усны тухай хууль"-ийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг " Усны газар "- ын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн Е-2509-000152 тоот ус ашиглуулах дүгнэлт, Хараа-Ерөө голын сав газрын захиргаанаас олгосон 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/63 тоот ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Усны нөөц ашиглуулагчийг төлөөлж Хараа-Ерөө голын сав газрын захиргааны Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн А.Батсуурь, Ус ашиглагчийг төлөөлж Төв аймаг Сүмбэр сум, 2-р багт орших МҮ-022597 тоот тусгай зөвшөөрөлтэй, 9011250023 тоот улсын бүртгэлийн, 5403316 тоот регистрийн дугаартай "Мэргэний хөндийн алтны шороон орд"-ийг ил аргаар олборлох, баяжуулах "Хаш-Аранга" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Ганбат нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2025 оны 09 дүгээр сарын 29-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаатайгаар байгуулав.

1.2. Гэрээг Монгол хэлээр 2% үйлдэж талуудад нэг нэг хувь хадгалагдах бөгөөд аль ч хувь нь хуулийн хүчинтэй баримт мөн.

1.3. Энэхүү гэрээнд тусгагдаагүй зүйлийг Монгол Улсын холбогдох хуулиар зохицуулна.

## Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1.Ус ашиглах зориулалт: Унд ахуй, Баяжуулах технологид болон, зам талбайн усалгаа, мод тарих хэрэгцээнд уурхайн шүүрлийн ус болон худгаас ашиглана. "Хаш-Аранга" ХХК нь 2025 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.2-т 2025 оны 3 сараас эхлэн 11 сарыг дуустал цагт 80-100 м3 элсийг угаах хүчин чадалтай СБ-60 маркийн угаах төхөөрөмжөөр 142.22 мян м3 элсийг угаан баяжуулахаар төлөвлөсөн байна.

2.2. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм"-ын дагуу үйлдвэрлэлийн хэрэгцээний усны хэмжээг тооцоход:

Техникийн хүчин чадлаар үйлдвэрлэл болон бусад үйл ажиллагаанд шаардагдах усны хэмжээг тооцвол:

138.0 хүн * 0.15 $м^3$ * 300 хон = 6,210.00 $м^3$ – Ашиг олох зориулалтаар ахуйд ашиглах усны хэмжээ

142200 тонн * 4,0$м^3$ = 568,800.00 $м^3$ – ашигт малтмал олборлон баяжуулахад шаардагдах усны хэмжээ.

43000,0 $м^2$ * 0.002$м^3$ * 21 удаа = 1,806.00 $м^3$ –Зам талбайн усалгаа хийх усны хэмжээ

1000.0 ширхэг * 0.035 $м^3$ * 21 удаа = 735.00 $м^3$ – Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модонд ашиглах усны хэмжээ.

50000.0 $м^2$ * 0.004 $м^3$ * 12 удаа = 2,400.00 $м^3$ – Дуйцүүлэн хамгаалахад зарцуулах усны хэмжээ.

735.00 $м^3$ * 1.0 $м^3$ * 300 хон = 220,500.30 $м^3$ – Уурхайд шүүрлээр орж ирэх усны хэмжээ.

**Нийт ашиглах усны хэмжээ:** 6,210.00 $м^3$ + 568,800.00 $м^3$ + 1,806.00 $м^3$ + 735.00 $м^3$+ 2,400.00 $м^3$ + 220,590.00 $м^3$ **= 800,541.00 $м^3$**

**2.3.Усны чанар, найрлага:** Үйлдвэрлэлд шавхан зайлуулах шүүрлийн ус хэрэглэнэ.

**2.4. Усны эх үүсвэрийн байршил, хоногт ашиглах усны хэмжээ:** Унд ахуйн хэрэгцээнд 20.7 $м^3$/хон усыг гүний худгаас авч ашиглана. Уурхайд шүүрэн орж ирэх усыг үйлдвэрлэлд ашиглана.

**2.5. Усны барилга байгууламж:**

Усан сан нь: 60м өргөн, 62м урт, 4м гүнтэй байна.

**2.6. Худаг өргөлтийн станцууд усны тоолуур насосны хүчин чадал:** LH637, Гаргалт диа.мм 100, Хүчин чадал, кВт 37, Бүтээл, м3/цаг 120, Шахалтын өндөр, м 80-90

**2.7. Дамжуулах байгууламж:** 100 диаметртэй уян хоолой

**2.8. Хаягдал усны хэмжээ цэвэрлэгээний арга:**

Унд ахуйн хэрэгцээнээс гарсан бохир усыг хөрсөнд нэвчүүлнэ.

**2.9. Байгаль орчны үнэлгээ,нөхцөл:**

"Мэргэний хөндийн алтны шороон орд"-ыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2024 онд "Грийн Солюшн консалтинг" ХХК хийж гүйцэтгэсэн.

**2.10 Онцгой нөхцөл:**

- Улирал бүр 2-с доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж дүнг улирал бүр сав газрын захиргаанд ирүүлэх

-Хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах

- Байгаль орчин аялал жуулчлалын сайд,Эрүүл мэндийн сайдын 2018 оны А82/128 тоот хамтарсан тушаалаар батлагдсан ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журмыг хэрэгжүүлэн ажиллах.

**2.11. Ус ашигласны төлбөрийн хэмжээ:**

Ашиг олох зориулалтаар үйлдвэрлэлд ашиглах **6,210.00 м$^3$** газрын доорх ус, уурхайн шүүрэн орж ирэх **220,590.00 м$^3$** газрын доорх усны төлбөрийн хэмжээг "Усны экологи-эдийн засгийн суурь үнэлгээг шинэчлэн батлах" тухай Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Хараа-Ерөө голын сав газарт тогтоосон газрын доорх усны экологи-эдийн засгийн суурь үнэлгээ, "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах" тухай Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтын итгэлцүүр, "Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох,хөнгөлөх" тухай Засгийн газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 326 дугаар тогтоолд заасан хувь хэмжээг ашиглан тооцвол:

Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах газрын доорх усны төлбөр: **6,210.00м$^3$ x 82.92 төг/м$^3$= 514,933.20 төг**

Уурхайд шүүрлээр орж ирэх усны төлбөр: **220,590.00м$^3$ x 580.44 төг/м$^3$= 128,039,259.60 төг**

- 82.92 төг/м$^3$ – Хараа-Ерөө голын сав газарт ашиг олох зориулалтаар хүнсний үйлдвэрлэлд газрын доорх ус ашигласан нөхцөлд экологи эдийн засгийн суурь үнэлгээ.
- 580.44 төг/м$^3$ м$^3$ – Хараа-Ерөө голын сав газарт шавхан зайлуулсан газрын доорх усны экологи эдийн засгийн суурь үнэлгээ.

**Нийт төлбөрийн хэмжээ: 514,933.20 төг + 128,039,259.60 төг = 128,554,192.80 төгрөг** (нэг зуун хорин найман сая таван зуун тавин дөрвөн мянга нэг зуун ерэн хоёр төгрөг наян мөнгө)

**Төлбөр төлөлт:** Усны нөөц ашигласны төлбөрийг Төв аймгийн төрийн сан банкны **100140100944** тоот дансанд 2025 оны 12 сарын 10-ний өдрийн дотор усны төлбөрийг бүрэн төлж барагдуулна.

Ус ашиглалтын мэдээ тайлан, болон усны нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлсөн (хагас, бүтэн жилээр төвлөрүүлж) тайланг Хараа-Ерөө голын сав газрын захиргаанд гаргаж өгнө.

Засгийн газрын 2018 оны 391 тоот тогтоолоор батлагдсан "Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журмын дагуу илүү ашигласан усны төлбөрийг илүү ашигласан усны эзлэх хувийн жингээр шатлан өсгөж төлөхөөр заасныг анхаарч, жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө, календарьчилсан графикийг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх.

**Гурав. Талуудын эрх, үүрэг**

**3.1 Гэрээ байгуулагч талууд нь** "Усны тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 22 дугаар зүйл, 24 дүгээр зүйл, 28 дугаар зүйл, 29 дүгээр зүйл 30 дугаар зүйлийн 30.1.2, 30.2, 31 дүгээр зүйлийн 31.2, 31.1.1 –д заасан зүйл заалтуудын дагуу эрх эдэлж үүрэг хүлээнэ.

**Дөрөв. Бусад**

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж , тамга, тэмдэг, дарж баталгаажсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг талууд 2025 оны 12-р сарын 01-ний өдрийн дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтууд болон дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцална.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн.

4.5.2. Аль нэг тал нь татан буугдсан.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

**Ус ашиглуулагчийг төлөөлж:**
ХЕГСГЗ-ны Усны барилга байгууламж, үйлдвэр Хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн................... А.Батсуурь

**Ус ашиглагчийг төлөөлж:**
"Хаш-Аранга" ХХК-ийн Гүйцэтгэх захирал
........................... Ч.Ганбат

ХАЯГ:

Дархан-Уул аймаг, Дархан сумын 14 баг, Монгол банкны 3 давхар, 301 тоот
Хараа-Ерөө голын сав газрын захиргаа
Утас: 70373171

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Токиогийн гудамж, Палаза төв 201А тоот.
Утас: 455069, 99111370

# Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: **365558699**

Татсан огноо: **2025-09-18 12:15**

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **8145102167**<br>**MN780015008145102167** | **MN200090100900013092**<br>**MN200090100900013092** | **790,000.00 MNT** | **Амжилттай** |
| Шилжүүлэгчийн нэр<br>**ХАШ-АРАНГА ХХК** | Хүлээн авагчийн нэр<br>**БОУАӨЯ. УСНЫ ГАЗАР** | Гүйлгээний утга<br>**Хаш-Аранга ХХК, РД:5403316** | |
| | Хүлээн авагчийн банк<br>**Төрийн сан** | Гүйлгээний огноо<br>**2025-09-18** | |

| Гүйлгээг шивсэн хэрэглэгч | Гүйлгээг хянасан хэрэглэгч | Гүйлгээг баталсан хэрэглэгч |
|---|---|---|
| **Ч. ГАНБАТ** | | ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН |

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

Нэгж талбарын дугаар: **4119021307**
Улсын бүртгэлийн дугаар: **Э-1420000341**
Гэрчилгээний дугаар: **0000387760**

# ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

**2025** оны **10** сарын **31** өдөр № **04164-2025/00045** **Төв** аймаг/хот **Сүмбэр** сум/дүүрэг

## Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, **Төв** аймаг /нийслэл/-ийн **Сүмбэр** дүүрэг /сум/-ын Сумын Засаг даргын захирамж **2024** оны **10** сарын **23** -ны өдрийн **04164-А/111/2024** тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж, **Төв** аймаг/хотын **Сүмбэр** сум/дүүргийн Газрын алба, газар эзэмшигчийг төлөөлж **Хаш-Аранга-ны захирал Чулуунбат овогтой Ганбат** нар энэхүү гэрээг байгуулав.

## Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ **558310 м2**

Үүнээс:

| Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт | Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ | Газар эзэмших хугацаа |
|---|---|---|
| Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж | 558310 м2 | 15 жил |

2.2. Газар эзэмших эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн хуульд заасны дагуу газрын төлбөрийг тооцож ногдуулна.

2.3. Газрын төлбөр нэхэмжлэхийн дагуу Татварын албанд тушаана. Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

2.4. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын суурь үнэлгээ, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, бүс, газар эзэмших, ашиглах зориулалтын итгэлцүүр, төлбөрийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг 30 хоногийн дотор шинэчлэн ногдуулна.

## Гурав. Газар эзэмшигчийн эрх

3.1. Гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг эзэмших, ашиглах;
3.2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;
3.3. Газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;
3.4.Газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх, барьцаалах;
3.5. Газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно.
3.6. Газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах /Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргах/;
3.7. Газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болсон тохиолдолд эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон Засаг даргын шийдвэрийг эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

## Дөрөв. Газар эзэмшигчийн үүрэг

4.1. Газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;
4.2. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;
4.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх/ 5 жилд нэг удаа хийлгэнэ./;
4.4. Бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
4.5. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хуульд заасан хугацаанд нь төлөх;
4.6. Төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх;
4.7. Эзэмшлийн газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх;
4.8. Газар эзэмшүүлэгчээс газрын эзэмшил ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;
4.9. Кадастрын зураглал гүйцэтгэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өөрийн эдлэн газартаа саадгүй нэвтрүүлж, ажиллах, мэдээлэл авах боломжоор хангах
4.10. Өөрийн эдлэн газрын хилийн эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэглэсэн тэмдэгтийг хамгаалалтандаа авч, бүрэн бүтэн байдлыг хариуцах
4.11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлэх
4.12. Эдлэн газрын эргэлтийн цэгүүдийг хөдөлгөсөн, нүүлгэн шилжүүлсэн, устгахгүй байх
4.13. Геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга буюу хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.
4.14. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэх
4.15. Барилга байгууламжийн төлөвлөлтийн эскиз зургийг сум болон аймгийн ерөнхий архитектороор батлуулах

4.16. Барилга байгууламжийн зураг төсөл нь хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шийдлүүд, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай уялдсан байх бөгөөд барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас илүүгүй байна.
4.17. Барилгын улаан шугам тавихад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэнг оролцуулан баталгаажуулах
4.18. Гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг заасан хугацаанд арилгах арга хэмжээ авах
4.19 Эзэмшил, ашиглалтанд байгаа болон орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжид тохижилт, арилчилгаа хийх
4.20. Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

## Тав. Газар эзэмшүүлэгчийн үүрэг

5.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж байгаа эсэхийг хянах;
5.2. Уг газрыг эзэмшүүлэхийн зэрэгцээ дараахь шаардлагыг газар эзэмшигчид тавих эрхтэй.
Үүнд:

а. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх

б. Эзэмшүүлэхээр олгосон газарт зориулалтын бус барилга байгууламж барих, хүн амын амьдрах орчны чанарт сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулахгүй байх

в. Газрыг зориулалтын дагуу эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллах

г. Хот тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана.

д. Барилгын зургийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ба барилгыг мэргэжлийн байцаагчаар хянуулах

е. Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд газар эзэмших гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах

5.3. Газрыг гэрээний нөхцөлийн дагуу эзэмшээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу Газрын тухай хуулийн 40.1.1-40.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тухайлбал:

а. Эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

б. Газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

в. Шилжүүлж авсан эрхийн гэрчилгээгээ улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;

г. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй;

д. эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;

е. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр* гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй* зэрэг тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд заасанаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

5.4. Газар эзэмшүүлэх гэрээг жил бүр дүгнэх;
5.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

## Зургаа. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

6.1. Газар эзэмшигчийн эзэмшилд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл **газар эзэмших эрх мөн адил шилжих болно** гэж шийдвэрлэнэ.
6.2. Энэхүү гэрээгээр эзэмших газрыг хязгаартай эзэмших эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь **газрын тухай хуулийн 48-р зүйлд** заасан нөхцөлийг дагаж мөрдөх болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.
6.3. Газар эзэмшигчийн газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гэрээний хугацаа дуусахаас өмнө эрх бүхий байгууллага улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргавал уг шийдвэрийн үндэслэл болсон талуудын урьдчилсан тохиролцоо болон бусад эрхийн актаар зохицуулна.
6.4. Гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл: **Эзэмших эрх бүхий газраа зориулалтын дагуу эзэмшээгүй болон газрын төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулаагүй тохиолдолд газар эзэмших эрхийг нь хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ. Мөн зохих зөвшөөрөлгүйгээр газрын хэмжээнд өөрчлөлт оруулсан нөхцөлд газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.**

Жич: “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ...” гэдгийг гэнэтийн давагдашгүй хүчний эсхүл байгалийн тогтолцооны өөрчлөлтөөс тухайн газарт нь эвдрэл, элэгдэл, цөлжилт бий болсон, бусдын хууль бус үйлдэл зэрэг газар эзэмшигчээс хамаарах шалтгаан байхгүй байсныг ойлгоно.

“… зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй” гэдгийг газар эзэмшүүлэх тухай гэрээ хийгдсэнээс хойш хуанлийн бүтэн 2 жилийн дотор газар эзэмшигч нь тухайн газар дээрээ гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй /барилга, байгууламж, зам талбай бариагүй, тариалан эрхлээгүй г. м/ байхыг ойлгоно.

## Долоо. Бусад зүйл

7.1. Гэрээ нь газар эзэмшигчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.
7.2. Газар эзэмшүүлэх гэрээг талууд жил бүр дүгнэх ба газар эзэмшигч гэрээний биелэлтийг жил бүрийн 06-р сарын 25-ны дотор багтаан тайлагнаж, газар эзэмшүүлэгч 07-р сарын 01-ний дотор багтаан дүгнэнэ.
7.3. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлээгүй, өмнөх гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, дахин давтагдсан тохиолдолд Газрын тухай хууль тогтоомжийн дагуу газар эзэмших, эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.
7.4. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
7.5. Газар олгох техникийн нөхцөл болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийн дагуу тухайн газар дээр байрлаж буй инженерийн шугам сүлжээг холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр нүүлгэн шилжүүлэх ба түүнтэй холбогдон гарах зардлыг газар эзэмших эрх авсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

**Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:**

Газар эзэмшүүлэгч:

Утас:

---

Газар эзэмшигч: **Хаш-Аранга**

Газрын байршил: **Төв Сүмбэр 2-р баг, Жавхлант Их бор 0**

Газар эзэмшигчийн хаяг: **Төв Сүмбэр 2-р баг, Жавхлант**

Регистр / улсын бүртгэл /-ийн дугаар: **/5403316/**

Банк, дансны дугаар: **,**

Харилцах утас: **99111370**

Газар эзэмшигч **Хаш-Аранга** нь гэрээний нөцөлийг Газрын нэгдмэл сангийн удирлагын цахим систем /www.egazar.gov.mn/-д **2025-10-31 15:00:45** цагт зөвшөөрч, баталгаажуулав.

Энэхүү гэрээний нэг хувийг **4119021307** дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.

ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

# Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: **S68427616202506173**

Татсан огноо: **2025-06-17 10:08**

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **8145102167**<br>**MN780015008145102167** | **100142300943** | **9,373,221.00 MNT** | **Амжилттай** |

| | | |
|---|---|---|
| Шилжүүлэгчийн нэр<br>**ХАШ-АРАНГА ХХК** | Хүлээн авагчийн нэр<br>**ТӨ.СҮ ГАЗРЫН ТӨЛБӨР** | Гүйлгээний утга<br>**ХАШ-АРАНГА ХХК, РД:5403316, 99111370,ТӨ.СҮ ГАЗРЫН** |
| | Хүлээн авагчийн банк<br>**Төрийн сан** | Гүйлгээний огноо<br>**2025-06-17** |

01 ГОЛОМТ БАНК ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

МОНГОЛ УЛС

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН**

# ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар: 0000387760**

| Хаш-Аранга | 5403316 |
|---|---|
| *(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)* | *(регистрийн дугаар)* |

Сумын Засаг даргын захирамж 20 24 оны 10 сарын 23 өдрийн А/111 тоот
*(шийдвэр гаргагч)*

| шийдвэрийг үндэслэн | Төв | Сүмбэр | 2-р баг, Жавхлант |
|---|---|---|---|
| | *(аймаг, нийслэл)* | *(сум, дүүрэг)* | *(баг, хороо)* |

| Их бор | 0 | хаягт |
|---|---|---|
| *(гудамжны нэр)* | *(хашааны дугаар)* | |

байрлах, нэгж талбарын 4119021307 дугаар бүхий 558310 м.кв газрыг

Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж зориулалтаар

15 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн Э-1420000341

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.

Энэхүү гэрчилгээ хүчинтэй эсэхийг QR кодыг уншуулж шалгах бөгөөд гэрчилгээнд агуулагдаж буй мэдээллийг харах боломжтой.

**Хэвлэсэн огноо: 2025-08-15**

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН 0000387760 ДУГААР БҮХИЙ ГЭРЧИЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ**

| Д/д | Хамтран эзэмшигч |
|---|---|
| 1 | Овог: ...<br>Эцэг /Эх/-ийн нэр: ...<br>Нэр: ...<br>Регистрийн дугаар: ...<br>Шийдвэрийн огноо, дугаар: ... оны ... сарын .. өдрийн ... тоот |
| **Д/д** | **Барьцаа** |
| 1 | Барьцаалсан эсэх: Үгүй |
| 2 | Нэмэлт барьцаа эсэх: Үгүй |
| 3 | Давхар барьцаа эсэх: Үгүй |
| 4 | Үнэт цаасны хөрөнгийн багцад бүртгэсэн эсэх: Үгүй |
| **Д/д** | **Сервитут** |
| 1 | Сервитут: Үгүй |

Энэхүү гэрчилгээ хүчинтэй эсэхийг QR кодыг уншуулж шалгах бөгөөд гэрчилгээнд агуулагдаж буй мэдээллийг харах боломжтой.

**Хэвлэсэн огноо: 2025-08-15**

ГОЛОМТ БАНК

# Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: 262736287

Татсан огноо: 2024-06-04 09:15

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **3205102377**<br>MN720015003205102377 | **100900013406** | **18,900,000.00 MNT** | **Амжилттай** |

| Шилжүүлэгчийн нэр | Хүлээн авагчийн нэр | Гүйлгээний утга |
|---|---|---|
| **ХААН БУЛАГ ИНТЕРНЭЙШНЛ** | **БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА** | **" Хаш аранга" ххк MV-022597 нөхөн сэргээлт барьцаа төлбөр 50 хувь** |
| | Хүлээн авагчийн банк<br>**Төрийн сан** | Гүйлгээний огноо<br>**2024-06-04** |

| Гүйлгээг шивсэн хэрэглэгч | Гүйлгээг хянасан хэрэглэгч | Гүйлгээг баталсан хэрэглэгч |
|---|---|---|
| **Ц. Баярцэцэг** | | 01 ГОЛОМТ БАНК ХУУЛБАР ҮНЭН |

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

**ГОЛОМТ БАНК**
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

# Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: **362199132**

Татсан огноо: **2025-09-02 12:13**

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **8145102167**<br>**MN780015008145102167** | **MN780090100900013406**<br>**MN780090100900013406** | **11,750,000.00 MNT** | **Амжилттай** |

| | | |
|---|---|---|
| Шилжүүлэгчийн нэр<br>**ХАШ-АРАНГА ХХК** | Хүлээн авагчийн нэр<br>**БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА** | Гүйлгээний утга<br>**MV-022597, Хаш-Аранга ХХК, 5403316, 2025 оны БО барьцаа** |
| | Хүлээн авагчийн банк<br>**Төрийн сан** | Гүйлгээний огноо<br>**2025-09-02** |

| Гүйлгээг шивсэн хэрэглэгч | Гүйлгээг хянасан хэрэглэгч | Гүйлгээг баталсан хэрэглэгч |
|---|---|---|
| **Ч. ГАНБАТ** | | 01 ГОЛОМТ БАНК ХУУЛБАР ҮНЭН |

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

ГОЛОМТ БАНК

# Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: 262736287

Татсан огноо: 2024-06-04 09:15

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **3205102377**<br>MN720015003205102377 | **100900013406** | **18,900,000.00 MNT** | **Амжилттай** |

| Шилжүүлэгчийн нэр | Хүлээн авагчийн нэр | Гүйлгээний утга |
|---|---|---|
| **ХААН БУЛАГ ИНТЕРНЭЙШНЛ** | **БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА** | **" Хаш аранга" ххк MV-022597 нөхөн сэргээлт барьцаа төлбөр 50 хувь** |
| | Хүлээн авагчийн банк: **Төрийн сан** | Гүйлгээний огноо: **2024-06-04** |

| Гүйлгээг шивсэн хэрэглэгч | Гүйлгээг хянасан хэрэглэгч | Гүйлгээг баталсан хэрэглэгч |
|---|---|---|
| **Ц. Баярцэцэг** | | ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН |

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

"НАРТ ШУУН КОНСАЛТИНГ" ХХК
**ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

Нарт ШУУН Консалтинг ХХК

MNAS Accreditation system TL 145 MNS ISO/IEC 17025

Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол
дүүрэг, 6-р хороо, 69 байр-1 ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836,
E-mail: nartconsulting@gmail.com

**№ 25/11-04/-1**

Захиалагч: **"Хаш-Аранга" ХХК**
Дээж авсан цэг**: Төв аймаг Сүмбэр сум (алтны орд) Тунаах нуур**
Сорьц авсан огноо: **2025 оны 10 сар 24 өдөр**
Уст цэгийн төрөл: **бохир ус**
Харилцах утас:
Аргын стандарт: **MNS4943:2015**

1. **Ерөнхий үзүүлэлтүүд**

| **Катион** | **1 дм$^3$** | | | **Анион** | **1 дм$^3$** | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **мг/л** | **мг-экв/л** | **мг-экв/%** | | **мг/л** | **мг-экв/л** | **мг-экв/%** |
| **$Ca^{++}$** | 44.00 | 2.20 | 47.19 | **$CO_3^{--}$** | 0.00 | 0.00 | 0.00 |
| **$Mg^{++}$** | 21.00 | 1.73 | 37.13 | **$HCO_3^-$** | 162.00 | 2.65 | 57.10 |
| **Fe** | 0.00 | 0.00 | 0.00 | **$Cl^-$** | 42.00 | 1.18 | 25.48 |
| **$K^+$** | 3.00 | 0.08 | 1.65 | **$SO_4^{--}$** | 35.00 | 0.73 | 15.68 |
| **$Na^+$** | 15.00 | 0.65 | 14.02 | **$NO_3^-$** | 5.00 | 0.08 | 1.73 |
| **Дүн** | **83.00** | **4.65** | **100.00** | **Дүн** | **244.00** | **4.65** | **100.00** |

Анион катионуудын нийлбэр:
($\sum_{A+K}$ **327 мг/л**
$HCO_3$-ийн хагасыг хассан анион,
катионуудын нийлбэр: **246 мг/л**
***Физик үзүүлэлтүүд***
Өнгө: **өнгө үгүй**
Үнэр: **үнэргүй**
Булингар: **Үл мэдэг булингартай**

Тунгалаг: **Тунгалагдуу**
Хуурай үлдэгдэл, мг/л: **227 ppm**
Ерөнхий **хатуулаг: 3.93 мг-экв/л**
*/ бага хатуулагтай ус /*
Урвалын орчин: pH- **8.06**
Цахилгаан дамжуулах чадвар:
EC **-0.541 ds/m**
TDS: **269 ppm**

2. **Бохирдлын үзүүлэлтүүд**

| д.д | Үзүүлэлтийн нэр | Хэмжих нэгж | Хэмжилтийн дүн | Зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | Усны температур | oC | 19.5 | 20 |
| 2 | Жинлэгдэх бодис /умбуур бодис/ | мг/л | 0.11 | 30 |
| 3 | Уусан хүчилтөрөгч | мгO/л | 2.05 | - |
| 4 | Зэс /Cu/ | мг/л | 0.13 | 1 |
| 5 | Зөөлөн цагаан /Кадми /Cd/ | мг/л | 0.00 | 0.03 |
| 6 | Никель /Ni/ | мг/л | 0.01 | 0.2 |
| 7 | Хартугалга /Pb/ | мг/л | 0.14 | 0.1 |
| 8 | Нийт хром /Cr/ | мг/л | 0.29 | 0.3 |
| 9 | Цайр /Zn/ | мг/л | 0.054 | 3 |
| 10 | Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян | **Илэрсэн** | илрээгүй | 1 мл-т илрэхгүй |

*Жич: усны сорьцыг шинжлүүлсэн байгууллага хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.*

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ: С.НЯМДАШ MSc
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D, Дэд проф.

# БАТЛАМЖ

........Хаанбулаг интернэйшнл ХХК..............-Д

Уурхай, уулын үйлдвэрт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний мэдлэг, дадлага олгох сургалтад хамрагдсан тул "Батламж" олгов.

**УУЛ УУРХАЙН АВРАХ 09 ДҮГЭЭР АНГИ**

**2025 он**

БАТЛАВ:

ЗАСАГ ДАРГА / Д.БАТБИЛЭГ /

# ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

№ 01

2024 оны 08-р сарын 19 Жавхлант

## Нэг: Нийтлэг үндэслэл.

**1.1.** Энэхүү гэрээний зорилго нь Сумын Засаг даргаас ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах талаар иргэн, аж ахуй нэгжтэй харилцан тохирсоны үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил гүйцэтгэх гэрээг байгуулах, хэрэгжүүлэх, дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулж, цэвэр орчин бүрдүүлж Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангахад оршино.

**1.2**. Энэ гэрээний эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын иргэний хуулийн 343-346, 350-353, 355 дугаар зүйлийн заалтууд байна.

**Нэг талаас:** Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрыг төлөөлж Байгаль орчны хяналтын улсын байцаагч Болдбаатар овогтой Цогзолмаа .

**Нөгөө талаас:** Сүмбэр суманд үйл ажиллагаа явуулдаг MV-022597 Тусгай зөвшөөрөлтэй “Хаш Аранга” ХХК-ны Гүйцэтгэх захирал Чулуунбат овогтой Ганбат нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

## Хоёр: Гэрээгээр гүйцэтгэх ажил, үйлчилгээ.

**2.1** Тухайн аж ахуйн нэгж, байгууллага үүсгэсэн хог хаягдлын төлбөр хураамжийг хугацаанд нь бүрэн төлөх .

**2.2** Хог хаягдлаа цуглуулан, тээвэрлүүлэх, саналаа нутаг дэвсгэр нэгжийн удирдлагад мэдэгдэж, ачигч болон тээврийн хэрэгсэлээр тогтоогдсон үнэ тарифаар үйлчлүүлнэ эрхтэй.

## Гурав: Хог хаягдал гаргагч этгээдэд ноогдуулах төлбөр хураамж.

**3.1** Хог гаргагч нь сар тутамд 300.000 / гурван зуун мянган/ төгрөг төлнө.

**3.2** Гэрээ байгуулснаас хойшхи 3 хоногийн хугацаанд хог гаргагч нийт төлбөр хураамжийг төлсөн байна.

**3.3** Хог гаргагч аж ахуй нэгж, байгууллага гэрээнд заасан төлбөрийг хугацаанд нь татварын байцаагчаар нэхэмжлэл үүсгэн төлнө.

## Дөрөв: Хугацаа

4.1. Гэрээ үргэлжлэх хугацаа 2024 оны 06-р сарын 8-наас 2024 оны 12-р сарын 31-нь байх ба үйл ажиллагаа үргэлжлэх хугацаа

4.2. Гэрээг жил бүрийн эхэнд шинэчлэн байгуулж, баталгаажуулан ажиллана.

## Тав: Талуудын эрх үүрэг

**5.1** Засаг даргын тамгын газрын хүлээх эрх, үүрэг .

**5.1.1** Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хог гаргагчаас шаардах.

**5.1.2** Хог гаргагч этгээдийн үйл ажиллагаатай танилцаж, мэргэжлийн зөвлөгөө зөвлөмжөөр хангаж ажиллах.

**5.1.3** Хог гаргагч этгээдийн санал бодлыг байнга сонсч шийдвэрлэж ажиллах.

**5.1.4** Хог гаргагч этгээдийн гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд мэдээ, мэдээлэлээр хангах.

## Зургаа: Хог гаргагч этгээдийн эрх үүрэг.

**6.2.1** Хог хаягдал гаргагч этгээд нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Засаг даргын тамгын газрын төлөөлөлөөс шаардах.

**6.2.2** Хог хаягдал гаргагч этгээд Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

**6.2.3** Хог хаягдал гаргагч этгээд нь зөрчил дутагдалгүй хөдөлмөр аюулгүй ажиллагааг чанд сахиж биелүүлэх .

**6.2.4** Үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллага нь Байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлынхаа мэдээ, /аюултай хог хаягдлын, шатах тослох материалын мэдээг/ тайланг сар тутамд гэрээ байгуулагч байгууллагад мэдээлж байх.

**6.2.5** Гэрээ байгуулагч талууд гэрээг гэрээний хугацаа дуусахаас 5 хоногийн өмнө хамтарч дүгнэнэ.

**Долоо . Хамтран хүлээх эрх үүрэг**

**7.1.1** Хоёр тал гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ эс биелүүлсэн тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах саналыг гаргаж хамтран шийдвэрлэнэ.

**7.1.2** Гэрээний талаар маргаан үүссэн тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

**7.1.3** Гэрээлэгч талууд Монгол Улсын "Хог хаягдалын тухай", "Зөрчлийн тухай хууль- ийн заалтаар хариуцлага хүлээнэ.

Төв аймаг Сүмбэр сумын төлөөлөл төлөөлөл:

Байгаль орчны хяналтын улсын байцаагч Болдбаатар овогтой Цогзолмаа

.......................................................

/ гарын үсэг /

2024.08.19

Хаш Аранга ХХК-ны

Гүйцэтгэх захирал:
Чулуунбат овогтой Ганбат

.......................................................

/ гарын үсэг /

2024.08.19

## МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР 2240803687920

**ТАТВАРЫН АЛБА:**

Татварын алба: **Төв**

Татварын дэд алба: **Сүмбэр**

Татварын төрөл: **01030723-Хог хаягдлын үйлчилгээний хураамж**

Тайлант хугацаа: **2024-1**

Төлөх дүн: **1500000**

**ТАТВАР ТӨЛӨГЧ:**

Регистр /ТТД: **5403316**

Татвар төлөгчийн нэр: **Хаш-Аранга**

Баримт үүсгэсэн огноо: **2024-08-28**

Төлөх огноо: **2024-08-28**

## МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР 2240803687920

**ТАТВАРЫН АЛБА:**

Татварын алба: **Төв**

Татварын дэд алба: **Сүмбэр**

Татварын төрөл: **01030723-Хог хаягдлын үйлчилгээний хураамж**

Тайлант хугацаа: **2024-1**

Төлөх дүн: **1500000**

**ТАТВАР ТӨЛӨГЧ:**

Регистр /ТТД: **5403316**

Татвар төлөгчийн нэр: **Хаш-Аранга**

Баримт үүсгэсэн огноо: **2024-08-28**

Төлөх огноо: **2024-08-28**

"ИРМҮҮН ОЙЛ ТРЕЙДИНГ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ЭРДЭНЭБАТ

"ХААН БУЛАГ ИНТЕРНЭЙШНЛ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.БАЯРБААТАР

# ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2025 оны 09-р сарын 19-ны өдөр № 25/08 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 6666612 тоот регистрийн, 9011824921 тоот улсын бүртгэлийн дугаартай **"Ирмүүн Ойл Трейдинг" ХХК-** г төлөөлж Нягтлан бодогч ажилтай Х.Оюунгэрэл_, нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 6195598 тоот регистрийн дугаартай **"Хаан булаг интернэйшнл" ХХК**-г төлөөлж Гүйцэтгэх захирал ажилтай Б. Баярбаатар нар дор дурдсан зүйлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын Иргэний хууль **/46-р бүлэг 369-р зүйл /** , Хог хаягдлын тухай хуулийн **/5-р зүйл , 5,4-т/** холбогдох зүйл заалтыг баримтлан энэхүү техникийн ажилласан тос бэлтгэн нийлүүлэх гэрээг байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ,

1.1 Энэхүү гэрээгээр "Ирмүүн ойл трейдинг" ХХК болон "Хаан булаг интернэйшнл" ХХК -ийн гэрээнд заасан хугацаанд машин механизмын, тоног төхөөрөмжийн, хөдөлгүүрийн, гидрийн болон моторын тосыг солих үед гарах техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдал /цаашид "АХХ" гэх/-г цуглуулах, тээвэрлэх, бэлтгэн нийлүүлэх болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү гэрээ нь талуудын хооронд хийгдсэн тохиролцоонуудыг агуулж байгаа бөгөөд энэхүү гэрээнд тодорхой байдлаар тусгаж оруулсан заалтуудыг оролцуулахгүйгээр үйлчилгээтэй холбоотой хэлцэл, мэдэгдэл, аман болон бичгээр хийсэн тохиролцоог энэхүү гэрээ орлож байгаа болно.

1.3 Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, хоёр тал гарын үсэг зураагүй бол тэдгээрийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Энэхүү гэрээ нь "Ирмүүн ойл трейдинг" ХХК болон "Хаан булаг интернэйшнл" ХХК-ийн төлөөлөлүүд гарын үсэг зурснаар 2026 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

2.2 Гэрээнд оролцогч талууд Монгол Улсын Иргэний хуульд заасны гэрээний үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд гэрээг дуусгавар болгохыг санал болгох эрхтэй.

2.3 Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээг үргэлжлүүлэх эсэх талаар харилцан мэдэгдэл ирүүлж сунгана.

2.4 Энэхүү гэрээний нөхцөл, болзол, заалтаас татгалзан дуусгавар болгох тухай санал, шалтгааныг талууд зөвхөн албан бичгээр тайлбарлан гаргана.

## ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Талууд бие биенээсээ энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, хэрэгжүүлэхийг шаардах бүрэн эрхтэй.

3.2 Талууд аюултай хог хаягдал /цаашид АХХ гэх/-г юүлэх, зөөх, тээвэрлэх, машинд ачиж буулгах зэрэг АХХ-г хөдөлгөх тухай бүрт хариуцлагатай байж, ажлын болон агуулахын талбай, газар шороо, байгаль орчинг бохирдуулахгүй байхад шаардлагатай арга хэмжээг авч хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

3.3 АХХ буюу техникийн хаягдал тосыг нийлүүлэгч тал нь ямар нэг биет хог /**эрэг, боолт, төмөр, чулуу, хуванцар, даавуу, гялгар уут гэх мэт/, механик хольц болон хөргөлтийн шингэн** /тосол/, хурдны хайрцагны тос /АКТ/-ны хольцгүйгээр аль болох нэг төрлөөр цуглуулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.

3.4 "Ирмүүн ойл трейдинг" ХХК нь "нийлүүлэгч тал" -ийн цуглуулан ангилж буй АХХ буюу техникийн хаягдал тосны чанарын асуудлаар бэлтгэн нийлүүлэгч талд бичгээр шаардлага хүргүүлэх эрхтэй.

3.5 Энэхүү гэрээний дагуу өгөх шаардлагатай эсхүл өгөхийг зөвшөөрсөн аливаа мэдэгдлийг бичгээр үйлдэх бөгөөд түүнийг биечлэн хүргүүлэх эсхүл доор заасан цахим шуудангийн хаягаар илгээсэн тохиолдолд аливаа мэдэгдлийг хүлээж авснаа талууд бичгээр хариу мэдэгдэж санхүүгийн анхан шатны баримт үйлдэн баталгаажуулах үүрэгтэй.

3.6 "Ирмүүн Ойл трейдинг" ХХК бэлтгэн нийлүүлэгчээс тээвэрлэгдэн ирсэн энэхүү гэрээний 3.3 заалтын дагуух АХХ-ыг тохирох эсэхийг өөрийн лабораторт судалж, шинжилсний үндсэн дээр хорогдол тооцон авах эрхтэй.

3.7 Энэхүү гэрээ байгуулсантай холбогдон олж авсан талуудтай холбоотой мэдээлэл, баримтын нууцлалыг гэрээ байгуулснаас хойш хоёр тал хугацаагүйгээр чанд хадгалах бөгөөд аль нэг тал нөгөө талд зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжийн дагуу шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, гэрээнд заагдаагүй зорилгоор ашиглахгүй байх үүрэгтэй.

3.8 Бэлтгэн нийлүүлэгчийн нийлүүлсэн техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдлыг хүлээн авснаар бүх эрсдэл, хариуцлага хүлээн авагч талд шилжинэ. Хүлээн авсан аюултай хог хаягдлыг "Ирмүүн ойл трейдинг" ХХК нь хэрхэн ашиглах, ашигласан нь нийлүүлэгч талд үл хамаарна.

## ДӨРӨВ. БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ

4.1 Бэлтгэн нийлүүлэгчийн нийлүүлж буй шаардлагыг хангасан техникийн хаягдал тос (АХХ)-ыг үнэ төлбөргүй, (1 литр тутмыг …..... төгрөгөөр ) "Ирмүүн ойл трейдинг" ХХК-д нийлүүлнэ. (доогуур зурах)

4.2 "Ирмүүн ойл трейдинг" ХХК- нь өөрийн эзэмшлийн .... тн –ийн нөөцийн савыг Бэлтгэн нийлүүлэгчийн талбайд байршуулж болох бөгөөд байршуулсан сав нь Ирмүүн ойл трейдинг" ХХК-ний өмч байна.

4.3 Хаягдал тосыг төлбөртэй тохирсон тохиолдолд авсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийг ..................ХХК-ийн эзэмшилийн ..................-ны .................. тоот дансанд шилжүүлнэ.

4.4 Бэлтгэн нийлүүлсэн АХХ-ын хэмжээг талуудын хүлээлгэн өгсөн болон хүлээн авсан ажилтны гарын үсгээр баталгаажсан санхүүгийн анхан шатны баримтын бичилтийг үндэслэн тогтооно.

4.5 Нийлүүлэгчийн бэлтгэн нийлүүлсэн техникийн хаягдал тос (АХХ)-ыг 30 000 литрээс багагүй хэмжээгээр нийлүүлсэн тохиолдолд "Ирмүүн ойл трейдинг" ХХК нь Байгаль Орчины Яаманд мэдээлдэг мэдээ тайландаа тусгаж тайлагнана.

## ТАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

5.1 Ямар ч тохиолдолд аль нэг тал түүний хяналтаас гарсан аливаа шалтгаан, нөхцөл байдлын улмаас шууд эсхүл шууд бус байдлаар, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй, үүргийн биелэлт нь хойшлогдсон тохиолдолд нөгөө талын өмнө хариуцлага хүлээхгүй.

5.2 Тийм шалтгаан, нөхцөл байдалд: гал түймэр, үер, ажил хаялт, үймээн, хорлон сүтгэх ажиллагаа, дэлбэрэлт, цаг уурын сөрөг нөхцөл, зайлсхийх боломжгүй золгүй явдал, ажиллах хүч, материал, тээвэр эсхүл үйлчилгээ олдохгүй байх, давагдашгүй хүчин зүйлс эсхүл дайсагнагч улсын үйл ажиллагаа, нөгөө талын үйлдэл, шүүхийн шийдвэр, тушаал, тогтоол эсхүл Засгийн газрын эрх бүхий байгууллагын журам эсхүл зөвшөөрлийг алдах явдал бөгөөд энэ бүхэн аль ч талын үйлдэлд үндэслэгдээгүй байх ёстой.

5.3 Дээрхээс шалтгаалах ажил зогсоолт эсхүл энэ гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээний гүйцэтгэл тасалдсаны улмаас цаг хугацааны хувьд хойшлогдох асуудлыг аль болох яаралтай засаж залруулна.

## ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

6.2 Энэхүү гэрээнд заасан хэлцлүүд хэрэгжсэн эсэхийг үл харгалзан гэрээнд тусгагдсан болон гэрээг бэлтгэх, хэрэгжүүлэх үед гэрээнд оролцогч талуудын зүгээс гарсан аливаа зардлыг талууд өөр өөрсдөө хариуцна.

## ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

7.1 Талууд харилцагч талынхаа бизнесийн нэр хүндийг хүндэтгэж, тэгш эрхийн зарчимд тулгуурлан ажиллана.

7.2 Талууд гэрээний хугацаанд харилцан ашигтай, найрсаг байдлаар хамтран ажиллаж аливаа маргааныг зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд хэрэв тодорхой зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу харъяалагдах шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

"Ирмүүн Ойл трейдинг" ХХК-ийн

Гүйцэтгэх захирал

Д.Эрдэнэбат

ИРМҮҮН ОЙЛ ТРЕЙДИНГ ХХК

/гарын үсэг/

НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

"Хаанбулаг интернэйшнл " ХХК-ийн

Гүйцэтгэх захирал

Б.Баярбаатар

/гарын үсэг/

## ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ:

Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 2 хэсэг, тэнгэр рашаан, 79в, 25
Утас: 99119328, 99664340
Цахим шуудан:
Irmuunoil.trading@gmail.com

Монгол улс, ......................................
..........................................................
..........................................................
Утас:...................................................
Цахим шуудан:

IRMUUN
OIL TRADING

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын
2018 оны 2-р сарын 2-ны өдрийн
А/21 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

# АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

Дагалдах бичгийн дугаар:
(шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэ)

**1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:**
Бүртгэлийн дугаар: Ү 6 | 1 | 9 | 55 | 98

**2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:**

| Овог нэр (дармал үсгээр бичих) | Гарын үсэг (тамга) | он | сар | өдөр |
|---|---|---|---|---|
| Хаанбулаг Интернэйшнл ХХК. | | | | |

**3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:** ТЭЭВЭРЛЭВ 0-26 УНЦ

1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар ________ Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар ________
Тээвэрлэгч аж ахуйн нэгжийн нэр: Ирмүүн Ойл-Трейдинг
2/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар ________ Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар ________
Тээвэрлэгч аж ахуйн нэгжийн нэр: ________

**4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:**

| № | Аюултай хог хаягдлын нэр | Аюулын ангилал | Савалгааны бүлэг | Савны төрөл | | Хэмжээ | Нэгж (кг, л) | Аюултай хог хаягдлын код |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дугаар | Төрөл | | | |
| | | А | 3500 | | ИРМҮҮН ОЙЛ ТРЕЙДИНГ ХХК УСТГАЛД ОРУУЛАВ | | | 1302 |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |

**5. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:**

**6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч:**

| | Гарын үсэг (тамга) | он | сар | өдөр |
|---|---|---|---|---|
| 1/ Овог нэр (дармал үсгээр бичих) Н. Батболд | | | | |
| 2/ Овог нэр (дармал үсгээр бичих) | | | | |

**7. Үл зохицол:**

**8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:**

Аж ахуйн нэгжийн нэр: Ирмүүн Ойл Трейдинг
Бүртгэлийн дугаар: 9 0 | 11 | 82 492
Аюултай хог хаягдлыг хүлээн авсан: Н. Батболд
Овог нэр (дармал үсгээр бичих) Гарын үсэг (тамга) 2025 он 9 сар 24 өдөр